



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/553

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 41.2.2 41.2.3, дахь заалт, Засгийн газрын 2018 оны 327 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Аймгийн онцгой комиссын 2024 оны 09 дүгээр хурал, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 25-р хурлыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 27 дугаар анги, Эрэн хайх аврах салбарын амьсгалын бие даасан төхөөрөмжийн баллон цэнэглэх төхөөрөмж шинээр авах шаардлагатай байгаа тул 12.000.000 (арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 12.000.000 (арван хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр олон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ